



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 10 сарын 05 өдөр

Дугаар А/581

Ховд

Улсын комисс байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4-ийн "а", Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан Ховд аймгийн Жаргалант сумын Бугат, Хайрхан багт инженерийн хийцтэй худаг гаргах ажлыг хүлээн авах улсын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Комиссын дарга: Б.Баярсүх - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга

Гишүүд: С.Гантөмөр - Жаргалант сумын Засаг дарга

М.Цогтэрдэнэ - Хүнс, хөдөө аж ахуйн газрын мэргэжилтэн

Д.Тогтохбаяр - Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын барилгын хяналт хариуцсан ахлах мэргэжилтэн

Т.Бямбажаргал - Байгаль орчны газрын усны асуудал хариуцсан мэргэжилтэн

У.Батзаяа - "Эвлэл" ХХК-ны захирал

Б.Түмэнжаргал - Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн

Б.Гантуяа - Хайрхан багийн Засаг дарга

Б.Түмэндэмбэрэл - Бугат багийн Засаг дарга


О.Дарьжав - Мэргэжлийн хяналтын газрын Эрүүл ахуйн халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч

Нарийн бичгийн

дарга: Ц.Пүрэвсүрэн - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

2. Инженерийн хийцтэй худаг гаргах ажлыг зураг төсвийн дагуу шалгаж хянан баталгаажуулж шийдвэр гаргахыг улсын комиссын дарга /Б.Баярсүх/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН